

“МОНОС ХҮНС” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 02 сарын 18-ны өдөр

№ 02/02

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2 заалт, 76 дугаар зүйлийн 76.1.12 заалт, “Монос хүнс” ХК-ийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.5, 11.6 заалтууд болон 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монос хүнс” ХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас нэгж хувьцаанд 1 (нэг) төгрөгөөр тооцон, нийт 408,850,428 (дөрвөн зуун найман сая найман зуун тавин мянга дөрвөн зуун хорин найм) төгрөгийн ногдол ашиг хуваарилахыг зөвшөөрсүгэй.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараах ажлыг Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвтэй байгуулсан гэрээний үндсэн дээр 2020 оны 08 сарын 31-ний өдрөөс эхлэн тарааж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (А.Отгондарь)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавих, ногдол ашиг тараах мэдээллийг зохих журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Н.Цагаанхүү)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л.ХҮРЭЛБААТАР